

2024 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН 10-НЫ ӨДРИЙН
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНД НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН УДИРДАХ
АЖИЛТНААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

Үүргийн биелэлтийг Arial-12 фонтоор бичиж, **2024 оны 09 дүгээр сарын 18-ны “Лхагва” гарагт** багтаан e-doc системээр албан бичгээр ирүүлж, ТЗУХ-ийн мэргэжилтэн (ERP Б.Одбаяр)-д файлаар ирүүлнэ үү. Хугацаа хэтэрсэн, албан бичгээр ирүүлээгүй тохиолдолд биелэлт ирүүлээгүйд тооцохыг анхаарна уу.

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГАААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
1	Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, ногоон байгууламжийн арчлалт, хамгаалалтын зардлыг төсөвт тусгаж байх зохицуулалтыг хийж ажиллах.	СТСХ, Багахангай тохижилт, Гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ-ууд
2	Дүүргийн нутгийн захиргааны бүх шатны байгууллагууд гадна орчны тохижилтыг хийх, дүүргүүд өөрсдийн нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж, байгууллагуудтай уулзалт зохион байгуулж, орчны тохижилтыг хийлгүүлэх ажлыг зохион байгуулах.	Дүүргийн менежер Г.Дагвадорж, Нийт байгууллагууд
3	Дүүргийн хэмжээнд байгаа хүүхдийн тоглоомын талбайн засвар, арчлалтыг хийж, эзэнжүүлэх ажлыг зохион байгуулах.	ТХҮХ, Багахангай тохижилт ОНӨААТҮГ
4	Хорооллын дундах автозамын засвар, шинэчлэл хийх саналаа Замын хөгжлийн газарт хүргүүлэх.	Дүүргийн менежер Г.Дагвадорж, ТХҮХ
5	Дүүргийн хэмжээнд архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр тодорхой ажил зохион байгуулах.	ТЗУХ, Цагдаагийн хэлтэс, ЭМТ
6	Дүүргийн нутгийн захиргааны бүх шатны байгууллагуудын ажилтан, албан хаагчид ажлын цаг ашиглалт, гүйцэтгэл, үр дүн, сахилга хариуцлага, ёс зүйн дүрэм журмуудыг мөрдөж ажиллах.	Нийт байгууллагууд
7	Хүнсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулж танилцуулах.	ЗДТГ-ТХҮХ
8	Дүүргүүд давс, бодис нөөцлөх ажлаа эрчимжүүлэх.	Дүүргийн менежер Г.Дагвадорж, ТХҮХ, Багахангай тохижилт ОНӨААТҮГ
9	Замын хөдөлгөөний дүрэм, журам зөрчсөн тээврийн хэрэгслийн жолооч нарт цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулж танилцуулах.	Цагдаагийн хэлтсийн Замын цагдаагийн хэсэг
10	Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хийгдэх ажлын саналаа “Улаанбаатар хотын хөгжлийн корпораци” ХК-д хүргүүлэх.	ЗДТГ-ТХҮХ, Нийт байгууллагууд
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
11	“Бүтээмж-Хамтын ажиллагааг дээшлүүлэх зорилтот жил”-ийн хүрээнд байгуулагдсан гэрээний биелэлтийг эрчимжүүлэх.	ЗДТГ, Холбогдох ААНБ-ууд
12	Хөрөнгө оруулалтаар хийгдэж буй ажлуудын гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах.	ЗДО Б.Болормаа, ЗДТГ, Холбогдох байгууллагууд, Ажлын хэсэг

13	Өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөөний биелэлтийг бүх шатанд жигд ханган ажиллах, өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх.	Нийт байгууллагууд
14	Тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт гарсан хяналтын постны үйл ажиллагааг эрчимжүүлэн, аюулгүй байдлыг хангах.	ОБХ
15	Дүүргийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудын гүйцэтгэлд аудит хийх.	ДАА
16	Дүүрэг, орон нутгийн татварын бааз суурийг нэмэгдүүлэх хүрээнд ААНБ-уудыг дүүрэгт шилжүүлэх ажлын зохион байгуулалтыг эрчимжүүлэх, 2024 оны 3 дугаар улирлын байдлаар дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй болон шилжин ирсэн ААНБ-уудын бүртгэлийг нэгтгэн, үйл ажиллагаа хэрхэн явагдаж байгааг танилцуулах.	ТХҮХ, Татварын хэлтэс, Ажлын хэсэг
17	Дүүргийн Засаг даргын захирамжийн биелэлтийг 2024 оны 3 дугаар улирлын байдлаар нэгтгэн Ажлын хэсэг байгуулсан захирамжуудын хэрэгжилтийг эрчимжүүлэх.	ЗДТГ-ын дарга Л.Санжийжамц, ЗДТГ, Нийт байгууллагууд
18	Дүүрэгт зохион байгуулагдах эдийн засгийн форумын бэлтгэл, бэлэн байдлыг сайтар хангах.	ЗДТГ, Ажлын хэсэг, Нийт байгууллагууд

БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР